



**Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа
БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ**

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

(2026 оны VII сар)

Сөүл хот, 2026 он

ГАРЧИГ

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ VII САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....3

1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ3

1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажил.....3

1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад хүргэсэн үйлчилгээ.....3-4

1.1.2. Бусад төрлийн визтэй болон визгүй оршин сууж буй иргэдэд үзүүлсэн үйлчилгээ5-6

1.1.3. Ур чадвартай ажилчны (Е-7-4) виз руу шилжихэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ6-7

1.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (хүснэгтээр)7

1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилсэн иргэний тоо7

1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт7

1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт.....8-9

2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ... 9

2.1. Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалтай холбоотой гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ.....9-10

2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажил10

2.3. Нийгмийн даатгалын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр).....12

3. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД АЖЛУУД

3.1. Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ.....11

3.2. Сургалт, сурталчилгаа, явуулын үйлчилгээ11-12

3.3. Нийгмийн даатгалын зөвлөгөө мэдээлэл, бусад үйлчилгээ11-12

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ VII САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн үйл ажиллагаа нь Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, хоёр улсын холбогдох яамдын хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хэрэгждэг.

Тус төв нь БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээг, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шаардлагатай төрийн үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага юм.

2026 оны VII сард төвийн дүрэм, хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэг, эрхлэх асуудлынхаа хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, иргэдэд хүргэсэн төрийн үйлчилгээг (хөдөлмөр, нийгмийн хамгаалал болон нийгмийн даатгалын чиглэлээр ангилж) энэхүү тайланд дурьдав.

1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

(Тайлант хугацаа 2026.07.01 - 2026.07.31)

1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажил

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2026 оны 07 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утас болон факсаар хандсан нийт **189** иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд, холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, орчуулгын үйлчилгээ үзүүлэх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх зэрэг үйлчилгээ үзүүлэн, иргэдийн гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажиллав.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын Самсунг даатгалын компаниас оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал 30,218,480 вон, нутаг буцах зардал 3,152,920 вон, Ажил олгогчоос үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү мөнгө 35,862,343 вон, олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс 1,000,000 вон нийт **70,233,743** воныг Монгол Улсын **21** иргэнд (давхардсан тоогоор) олгуулав.

1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад хүргэсэн үйлчилгээ

- Иргэн Г.М (Е-9) 13 дахь сарын цалин 7,407,610 вон, нутаг буцах замын зардал 537,000 вон, нийт 7,944,610 воныг олгуулсан.
- Иргэн Г.М (Е-9) 13 дахь сарын цалингийн зөрүү болох 7,000,000 воныг ажил олгогчоос нэхэмжлэн олгуулсан.
- Иргэн Э.Т (Е-9) нутаг буцах зардал 537,000 вон, 13 дахь сарын цалин

- 7,959,510 воныг олгуулсан.
- Иргэн Б.Т (Е-9) нутаг буцах зардал 541,140 воныг Аж үйлдвэр, хүний нөөцийн хэрэг эрхлэх газраас, 13 дахь сарын цалин 5,093,580 воныг Самсунг даатгалын газраас олгуулсан.
 - Иргэн Ж.Б (Е-7) нутаг буцах зардал 537,640 вон, 13 дахь сарын цалин 3,788,680 воныг олгуулсан.
 - Иргэн Г.Б (Е-7) үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн тооцооллыг хийж, харьяа Хөдөлмөрийн хэлтэс (고용노동부 천안고용노동지청)-т өргөдөл гарган 10,799,763 воныг олгуулсан.
 - Иргэн Б.Н (Е-7) нутаг буцах зардал 500,000 воныг олгуулсан.
 - Иргэн У.С (Е-9)-ийн Самсунг даатгалын газраас нутаг буцах зардал 500,140 воныг олгуулсан.
 - Иргэн Н.З (бусад) 13 дахь сарын цалингийн тооцооллыг хийж, Зүүн бүсийн Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх газарт өргөдөл гаргасан. Өргөдлийн дагуу ажил олгогч цалинг өгөхөөр тохирсон тул өргөдлийг шийдвэрлэв.
 - Иргэн Г.М (Е-9) гэрээний хугацаа дуусахаас өмнө өөрийн хүсэлтээр нутаг буцах хүсэлтэй байна гэсний дагуу дэлгэрэнгүй зөвлөгөө, мэдээлэл өгсөн.
 - Иргэн П.Б (Е-9) нутаг буцах зардлын холбогдох материалыг бүрдүүлж Самсунг даатгалын компанид илгээж шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.
 - Иргэн Б.С (Е-9) гаргасан өргөдлийн дагуу олгогдоогүй цалин хөлстэй холбоотой асуудлаар Хөдөлмөр халамжийн газар, Сөүлийн баталгаат цалингийн даатгалын газраас 4,286,000 вонын цалин хөлсийг нэхэмжлэх хүсэлт гаргаж шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.
 - Иргэн М.Б (Е-9) ажил олгогч хууль зөрчсөн заалт бүхий хөдөлмөрийн гэрээнд гарын үсэг зурахыг шаардаж байна гэх гомдлыг хүлээн авч, ажилтны эрх ашгийг хамгаалахаар **충주고용노동지청**-д хүсэлт гаргасан ба гэрээт ажилтныг **오산 이주노동자센터**-оос **충남광역외국인노동자쉼터** хүртэл тээвэрлэж хамгаалах байранд үнэ төлбөргүй байрлуулах (үнэгүй хоолтой) ажлыг зохион байгуулав. Түүнчлэн ажил олгогчоос хуульд заасан хугацаанд цалин хөлсийг олгоогүй тул **충주고용노동지청**-д цалингийн гомдлыг гарган холбогдох ажиллагаа хийж байна.
 - Иргэн Х.Н (Е-9) ажлын байр солих хүсэлтийг хүлээн авч ажил олгогчтой ярилцсан. Ажил олгогчоос ажлын байр солих боломжгүй, тогтвортой ажиллах хүсэлтийг гаргаж, ажилтантай мөн тохиролцсоноор үргэлжлүүлэн ажиллахаар болсон.
 - Иргэн Э.М (Е-9) нь нутаг түр буцах хугацаанд ажил олгогчоос хөдөлмөрийн гэрээг сунгаагүй, ажлаас халсан гэх өргөдлийг хүлээн авч Цагаачлалын албаны хүний эрх, эрх ашгийг хамгаалах багт 2026.06.11-ний өдөр, ажлаас үндэслэлгүй халсан талаарх гомдлыг боловсруулан **경기지방노동위원회**-д 2026.06.26-ний өдөр тус тус гомдлыг гаргасан.

1.1.2. Бусад төрлийн визтэй болон хууль бусаар оршин сууж буй иргэдэд үзүүлсэн үйлчилгээ

- Иргэн С.Д (визгүй) хууль бусаар ажилласан 13 дахь сарын цалин болох нийт

- 6,750,000 воныг ажил олгогчоос нэхэмжлэн олгуулсан.
- Иргэн Х.М (визгүй) самсунг даатгалын 13 дахь сарын цалин болох 5,969,100 воныг олгуулан ажиллалаа.
 - Иргэн Б.Т (бусад) БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд төлсөн шимтгэлээ буцаан авах талаар дэлгэрэнгүй мэдээлэл, зааварчилгаа өглөө.
 - Иргэн Т.Б болон Л.Мн (бусад) нарын олгогдоогүй цалин хөлстэй холбоотой асуудлаар, Инчон хотын Хууль зүйн туслалцаа үзүүлэх төвд өргөдөл гаргасны дагуу одоо шүүхийн шатанд шилжүүлэн ажилласан.
 - Иргэн Ц.Х (визгүй) гаргасан 13 дахь сарын цалин олгуулах тухай өргөдлийн ажил олгогч нь тогтоогдохгүй байх тул өргөдөл гаргагчийн хүсэлтийн дагуу өргөдлийг хаасан.
 - Иргэн Д.Д (визгүй) олгогдоогүй цалин хөлс нэхэмжлүүлэх өргөдлийг хүлээн авч Чангвон хотын хөдөлмөрийн хэлтэсрүү шилжүүлсэн.
 - Иргэн Б.О (визгүй) олгогдоогүй цалин хөлс нэхэмжлүүлэх өргөдлийг хүлээн авч Чангвон хотын хөдөлмөрийн хэлтэсрүү шилжүүлсэн.
 - Иргэн А.Б (визгүй) олгогдоогүй цалин хөлс нэхэмжлүүлэх өргөдлийг хүлээн авч Чангвон хотын хөдөлмөрийн хэлтэсрүү шилжүүлсэн.
 - Иргэн Г.С (визгүй) олгогдоогүй цалин хөлстэй холбоотой материалын бүрдүүлэлт хийж, ажил олгогчтой (김석현) холбогдож өргөдлийг шийдвэрлэх явц үргэлжилж байна
 - Иргэн Э.Т (визгүй) олгогдоогүй цалинтай холбоотой материалын бүрдүүлэлт хийж, өргөдлийг Инчоны Хөдөлмөрийн асуудал эрхлэх газарт (고용노동부 중부지방고용노동청 인천지청장 귀하) илгээж өргөдлийн шийдвэрлэх явц үргэлжилж байна
 - Иргэн Б.Г (визгүй) Сайн дураар нутаг буцах тухай хүсэлт гаргасны дагуу холбогдох материалыг бүрдүүлэн БНСУ-ын Цагаачлалын албаны цахим системд урьдчилсан мэдэгдлийн анкетийг бөглөн илгээлээ.
 - Иргэн Э.Т (визгүй) барилгын ажил гүйцэтгээд авч чадаагүй цалинг ажил олгогчоос нэхэмжилж 1,000,000 воныг олгуулсан.
 - Иргэн Ж.Б (визгүй) олгогдоогүй цалин болох 5,325,000 сая воны материалыг хүлээн авч бүрдүүлэлт хийж ажил олгогч болон хариуцсан менежертэй нь холбогдон нэхэмжилсэн.
 - Иргэн Ч.О (визгүй) ажлаас гарсны дараах тэтгэмж 6,649,746 олгуулах хүсэлтийг хүлээн авч тооцооллыг хийн ажил олгогчтой тохиролцоогүй тул 2026.07.01-ний өдөр 구미고용노동지청-д өргөдлийг гаргав.
 - Иргэн Б.Н (визгүй) үйлдвэрлэлийн осолд өртөж ажилгүй байсан үеийн цалин хөлсийг нэхэмжлэх гомдлыг 2026.06.05-ны өдөр хүлээн авч Каннам болон Чонан Хөдөлмөр халамжийн хэлтэст 9 удаагийн хүсэлтийг гарган 6,901,740 воныг олгуулаад байна. Ажил олгогчоос 1,220,000 вонын цалин хөлс олгоогүй асуудлаар өргөдлийг боловсруулан 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Сөүл Каннам салбарт гомдлыг гаргасан.
 - Иргэн О.Б (визгүй) олгогдоогүй цалин хөлс 4,000,000 вон олгуулах хүсэлтийг 2026.03.18-ны өдөр хүлээн авч 목포고용노동지청-д гомдлыг гаргасан. Ажил олгогч 2,370,000 олгохоор тохиролцох хүсэлтийг гаргаад байна.

- Иргэн Г.Д нарын 5 хүний (визгүй, G-1) олгогдоогүй цалин хөлс 3,110,000 вон олгуулах хүсэлтийг 2026.04.16-ны өдөр хүлээн авч материал бүрдүүлэн 중부지방고용노동지청-д гомдол гаргасан. Ажил олгогч өртэйн улмаас цалин хөлсийг авах боломжгүй байх тул өргөдлөө буцаан татах хүсэлт гаргасны дагуу өргөдлийг хаав.
- Иргэн Б.Б ажлын байрны дарамтад өртсөн асуудлаар холбогдох газруудтай уулзан хүсэлтийг Пусан хотод суугаа Консулын газарт илгээж ажиллав.

1.1.3. Ур чадвартай ажилчны (E-7-4) виз руу шилжихэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

- Хөдөлмөрийн гэрээт ажилчны E-9 визээс ур чадвартай ажиллах хүчний E-7-4 виз рүү шилжсэн иргэдийн судалгаанд тайлант хугацаанд 4 иргэнийг шинээр бүртгэсэн.
- Хөдөлмөрийн гэрээт ажилчны E-9 визээс ур чадвартай ажиллах хүчний E-7-4 виз рүү шилжих хүсэлтэй болон хугацааны болзол хангасан иргэдийн судалгаанд 4 иргэнийг шинээр бүртгэсэн.
- E-7-4 визний асуудлаар нийт 27 иргэнтэй утсаар болон цахимаар холбогдож бүрдүүлэх баримт бичиг, оноо тоолох, гэр бүлээ урих, ТОПИК шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэх, жолооны үнэмлэх авах, ажлын байр солих, D-10, F-2, E-7-4R, F-2R ангилал руу өөрчлөх зэрэг асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгсөн.
- Иргэн Э.М гаргасан өргөдлийн дагуу шаардлагатай баримт бичгийн бүрдлийг хангаж, хянан, Hometaх сайтаас 2024,2025 оны татварын гэрчилгээ гаргаж, ажил олгогчтой 4 удаа холбогдож орчуулга хийн туслалцаа үзүүлсэн ба E-7-4 визийг Сувоны Цагаачлалын албанд мэдүүлсэн.
- Иргэн Л.Б гаргасан өргөдлийн дагуу шаардлагатай 12 төрлийн баримт бичгийн бүрдлийг хангаж, хянан, Socianet сайтаас хэлний онооны гэрчилгээг гаргаж, ажил олгогчтой 6 удаа холбогдож орчуулга хийн туслалцаа үзүүлсэн ба E-7-4 визийг Сувоны Цагаачлалын албанд мэдүүлсэн.
- Иргэн Х.Д (E-7) нь гэр бүлээ урихад хэлний оноо шаардлагатай байгаа тул Нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалт (사회통합프로그램), түвшин тогтоох шалгалт (KIIP 사전평가)-д бүртгүүлсэн.
- E-7-4 визний асуудлаар “E-7-4 визний мэдээлэл солилцох групп” сошиал групп үүсгэн визээ сольсон, солих хүсэлтэй иргэдийг нэгтгэж байгаа ба гишүүдийн тоо 1215 байна. Мэдээлэл сурталчилгааг идэвхжүүлэх зорилгоор тус сошиал хуудсанд нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн шалгалтын бүртгэл эхэлсэн тухай, E-9 гэрээт ажилтныг илгээх процесс, цалин хөлс олгоогүй ажил олгогчид авах арга хэмжээ, эмнэлгийн үнэ төлбөргүй үзлэгийн бүртгэл эхэлсэн тухай зэрэг 10 удаагийн мэдээлэл зөвлөгөөг нийтэлсэн.

1.4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (хүснэгтээр)

1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилсэн иргэний тоо

Тоон мэдээллийн агуулга	Гүйцэтгэлийн тоон үзүүлэлт
-------------------------	----------------------------

		Иргэн	Олгуулсан дүн (вон)
Хөдөлмөрийн гэрээт ажилчдад	1) Нутаг буцах зардал	6	3,152,920
	2) Цалин, илүү цагийн хөлс		
	3) Самсунгийн 13 дахь сарын цалин	5	30,218,480
	4) Үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү мөнгө	2	17,799,763
	5) Үйлдвэрлэлийн ослын даатгал		
	6) Гэнэтийн ослын даатгал		
	7) Гэнэт халагдсаны тэтгэмж		
	8) Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад	3	
Бусад төрлийн визээр оршин суудаг иргэдэд	9) Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс	1	1,000,000
	10) 13 дахь сарын цалин	2	2,820,000
	11) Үйлдвэрлэлийн ослын даатгал		
	12) Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
Хууль бусаар оршин суудаг иргэдэд	13) Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс		
	14) 13 дахь сарын цалин	3	15,242,580
	15) Үйлдвэрлэлийн ослын даатгал		
	16) Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад	2	
Монгол Улсын иргэдэд олгуулсан дүн		21	70,233,743

1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт

Нийт өргөдөл	Шинээр хүлээн авсан өргөдөл	Шийдвэрлэлтийн байдал			
		Хугацаанд нь шийдвэрлэсэн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Шийдвэрлэж буй
96	17	12	79	-	5

1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт

Үйлчилгээ			Тоо
1)	Самсунг даатгалын газраас 13 дахь сарын цалин болон нутаг буцах замын зардал авах материалыг бүрдүүлэн, даатгалыг олгуулах, буцахтай холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгөх	нутаг	12
2)	Үйлдвэрээс авах 13 сарын цалингийн зөрүү бодолт хийх аргачлалыг танилцуулах, бодолт хийх, ажил олгогчоос нэхэмжлэн олгуулах		9
3)	Гэрээт ажилчдын ажлаас гарах өргөдөл гомдлын дагуу судлан, шийдвэрлүүлэх	асуудлыг	12
4)	Олгогдоогүй цалин хөлсний маргааныг шийдвэрлэж, цалин, хөлсийг		18

олгуулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх	
5) Цалин, илүү цаг, амралтын хөлсийг бодох болон тооцоолох аргачлалын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	
6) Үйлдвэрлэлийн ослын тухай, осолд орсон иргэнийг ослын даатгалд хамруулж, ажилгүйдлийн тэтгэмж болон нөхөн олговрыг олгуулах	
7) Гэнэтийн ослын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, даатгалд хамруулж, нөхөн олговрыг олгуулах	
8) Үндэслэлгүй болон ажил олгогчийн буруутай үйлдлээс шалтгаалан ажлын байр сольсон, гэнэт халагдсан тохиолдолд материалыг бүрдүүлэн, гэнэт халагдсаны тэтгэмж, бусад тэтгэмжийг олгуулж, өргөдлийг шийдвэрлүүлэх	3
9) Хөдөлмөрийн гэрээ сунгах (1жил 10сар), тусгай болон тогтвортой нөхцөлөөр дахин ирэх, давтан гэрээ байгуулахтай холбоотой бүх төрлийн мэдээлэл, зөвлөгөө өгөх	1
10) Бүх төрлийн аман болон бичгийн орчуулгын үйлчилгээ. Үүнд: БНСУ-ын Засгийн газрын байгууллага: - Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам - Хөдөлмөрийн хэлтэс - Төв бирж - Эрүүл мэндийн газар - Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв - Үндэсний тэтгэврийн алба - Хөдөлмөр, халамжийн газар Хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагатай холбоотой аман болон бичгийн орчуулга	7
11) Хөдөлмөрийн гэрээт иргэдийн хамрагдах даатгал (ЭМД, ГОД, ҮОД, НД)-ын асуудлаар нарийвчилсан мэдээлэл, зөвлөгөө өгөх	4
12) Жилийн эцсийн тайлангаар ХАОАТ-ын буцаалт хэрхэн авах тухай мэдээлэл хүргэх, зөвлөгөө өгөх	
13) Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх газар (ХЭХЯ), Шүүхийн шатанд өргөдөл, гомдол гаргах асуудлыг шийдвэрлэх, Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв, Хөдөлмөр халамжийн корпорац, Сөүлийн баталгаат цалингийн даатгалын газарт иргэний өргөдлийг дамжуулан өгч шийдвэрлүүлэх	1
14) Монгол иргэдийн сайн дураар нутаг буцах мэдэгдэл гаргах, оршин суух хугацааг шалгах, сунгах хүсэлт гаргах, цаг авахад туслах	3
15) Визний ангилал солиулахад (Е9-өөс Е-7-4 виз рүү) оноо цуглуулах, топик шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэхэд мэдээлэл, зөвлөгөөгөөр тусалж, дэмжих	28
16) Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх	22
17) Бусад мэдээлэл, зөвлөгөө	38
18) ХурДан төрийн цахим үйлчилгээг хүргэх	31
	Утсаар 102
	Цахимаар 51
	Танхимаар 36
	Нийт 189

Хүргэсэн үйлчилгээний тоо

2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

(Тайлан хамарсан хугацаа 2026.07.01 - 2026.07.31)

2.1. Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалтай холбоотой гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа болон бусад хэлбэрээр ажиллаж, амьдарч байгаа иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар хамруулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх үйл ажиллагаа:

- Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж буй иргэдээс 22 иргэнийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан. Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:
 - 31 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
 - 1 иргэнд дахин гэрчилгээ олгосон;
 - 17 иргэнд шинээр гэрчилгээ олгосон. Нийт 49 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үзүүлсэн.
- БНСУ-д бусад төрлийн визтэй оршин суугч Монгол иргэдээс 42 иргэнийг сайн дурын даатгалд хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан. Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:
 - 29 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
 - 17 иргэнд дахин гэрчилгээ олгосон;
 - 21 иргэнд шинээр гэрчилгээ олгосон. Нийт 67 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилсэн.

2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажил

Тайлант хугацаанд тус тасаг 235,986,861.46 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн бөгөөд орлогын сарын төлөвлөгөө 53.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шимтгэлийн 116.565,144.00 төгрөгийн орлогыг БНСУ-ын 3 банкны сангийн харилцах данснаас Нийгмийн даатгалын ерөнхий газрын Төрийн банк дахь төвлөрүүлэх дансанд бүрэн шилжүүлж, сарын мэдээг хуульд заасан хугацаанд гаргасан. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хуульд тус тус заасны дагуу тайлан, мэдээллийг Сангийн яамны холбогдох мэдээллийн санд байршуулсан.

2026 оны 06 дугаар сард нийт 48 даатгуулагчийн 3 болон түүнээс дээш сарын 39,259,360.00 төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулсан. Үүнд, албан журмын даатгалын 20 даатгуулагчийн 17,917,000.00 төгрөг, сайн дурын даатгалын 28 даатгуулагчийн 21,342,360.00 төгрөг байна.

2.3. Нийгмийн даатгалын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр)

Үйлчилгээ	Тоо	Өссөн дүнгээр
Албан журмын даатгал	22	223

1.	Даатгалд хамруулсан	шинээр	Сайн дурын даатгал	32	284
2.	Үндэсний даатгалаас гэрчилгээ олгосон (Албан журмын даатгал)	тэтгэврийн чөлөөлөгдөх	Шинээр	17	202
			Дахин	1	19
			Хугацаа сунгасан	31	197
3.	Үндэсний даатгалаас гэрчилгээ олгосон (Сайн дурын даатгал)	тэтгэврийн чөлөөлөгдөх	Шинээр	21	143
			Дахин	4	33
			Хугацаа сунгасан	29	202
4.	Шимтгэлийн төвлөрүүлэлт	орлого	Албан журмын даатгал	68,540,000 38%	707,122,650.00 42%
			Сайн дурын даатгал	167,446,861.46 104%	1,225,250,028,07 91%
			Нийт	235,986,861.46 53%	1,932,372,677.46 62,60%
5.	Гурав болон сарын шимтгэлийн барагдуулалт	түүнээс дээш авлага	Албан журмын даатгал	17,917,000	201,325,428.00
			Сайн дур	21,342,360.00	157,083,411.00
6.	БНСУ-ын тэтгэврийн буцаан олголт	Үндэсний даатгалын	Нэхэмжилсэн	42,257,940,00	112,237920,00
			Олгосон	0	131,253,410
			Буцаан олголт хүний тоо авсан	0	28
7.	Иргэдэд өгсөн мэдээлэл	зөвлөгөө,	Утсаар	253	2324
			Цахимаар	13	189
			Танхимаар	54	460

3. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН БУСАД АЖЛУУД

3.1. Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ

Тайлант хугацаанд сэтгэлзүйн ганцаарчилсан зөвлөгөөг нийт 22 иргэнд тусламж үзүүлсэн. Үүнээс хүйсээр ангилахад эрэгтэй 3 иргэн, эмэгтэй 19 иргэн тусламж үйлчилгээ авсан.

Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тулгамдсан асуудлаар нь ангилж үзвэл:

- Сэтгэл гутрал – 6
- Сэтгэл түгшилт – 3
- Гэр бүлийн асуудалтай – 4
- Нойрны өөрчлөлт – 1
- Биеийн хэлбэрийн өөрчлөлт – 2
- Бусад шалтгаан – 6

“Хосын зөрчил юунаас үүсдэг вэ, түүнд хэрхэн менежмент хийх вэ” сэдэвт цахим сургалт амжилттай зохион байгуулагдлаа. Манай төвөөс уламжлал болгон зохион байгуулдаг ээлжит сэтгэлзүйн цахим сургалтыг хийсэн.

Энэ удаагийн сургалтыг БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн мэргэжилтэн Б.Мөнх-Эрдэнэ, сэтгэл засалч эмч Д.Хонгорзул

нар “Хосын зөрчил юунаас үүсдэг вэ, түүнд хэрхэн менежмент хийх вэ” сэдвийн хүрээнд удирдан явууллаа. Сургалтын үеэр хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж, амьдарч буй иргэдэд түгээмэл тохиолддог сэтгэлзүйн асуудлууд, тэр дундаа хосын харилцаанд үүсдэг зөрчил, түүний шалтгаан, урьдчилан сэргийлэх болон зөв зохистойгоор шийдвэрлэх арга замын талаар мэдээлэл өгч, оролцогчдын санал бодлыг сонсон харилцан ярилцлаа.

Тус сургалтад нийт 22 иргэн хамрагдан, идэвхтэй оролцож, харилцааны ур чадвар, зөрчилдөөнийг зөвөөр удирдах арга барилын талаар мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлсэн үр өгөөжтэй сургалт болсон.

3.2. Сургалт, сурталчилгаа, явуулын үйлчилгээ

- “Хариуцлагатай амьдарцгаая” аяны хүрээнд тус төв нь БНСУ дахь Монгол Улсын Элчин сайдын яамтай хамтран оюутан, залууст зориулсан “Гадаад оронд хэрхэн хурдан дасан зохицох вэ” сэдэвт сэтгэлзүйн зөвлөгөө, сургалтыг амжилттай зохион байгууллаа. Тодруулбал, 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Конкук их сургуулийн 30 гаруй, оюутан, залуус сургалтад хамрагдав.
- БНСУ дахь Монгол Улсын Элчин сайдын яамны консулын хэлтэс болон Тэжон хотын Элбэг мах хүнсний дэлгүүртэй хамтран “Монголын нэг өдөр Тэжон Монгол наадам 2026” явуулын үйлчилгээ үзүүлэн ажиллалаа. Тус төвөөс байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаа болон Монгол Улсын Нийгмийн даатгалын хууль тогтоомж, хөдөлмөрийн харилцааны талаар зөвлөгөө, мэдээлэл өгч 60 иргэнд нийгмийн даатгал, хөдөлмөрийн харилцаатай холбоотой тараах материал тарааж ажилласан.
- 2026.07.04-нд БНСУ-ын Чонан хотод явуулын үйлчилгээ үзүүлэн ажилласан. Уг үйл ажиллагаагаар нийт 60 гаруй иргэнд байгууллагын танилцуулга материал тарааж, 6 иргэнд биечлэн зөвлөгөө мэдээлэл өгсөн. 27 хүүхдэд үндэсний өв соёлыг таниулах үүднээс шагайн наадгайг зохион байгуулсан.
- 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Сөүл хотод байрлах Дунхэсүсан (동해수산) компаниас ирүүлсэн хүсэлтийн дагуу хамт монгол 13 ажилтнаас ажлын байр орхих асуудал гаргасан, компанийн дотоод журмын зөрчих асуудал гаргаж байгаа тул уулзаж хууль эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажиллав.

3.3. Нийгмийн даатгалын зөвлөгөө мэдээлэл, бусад үйлчилгээ

БНСУ-д амьдарч буй иргэд болон хөдөлмөрийн гэрээт иргэдийг зөвлөгөө мэдээллээр дэмжих, өргөдөл гомдлыг шийдвэрлүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Тайлант хугацаанд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг танилцуулах, Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах талаар зөвлөгөө мэдээллийг өгөх үйлчилгээг утсаар 253, цахимаар 13, танхимаар 54 нийт 346 иргэн, даатгуулагчид үйлчилгээ үзүүлсэн.
- 2026 оны 07 дугаар сарын 23-ны өдөр БНСУ-ын хот дахь сургалтын төвд Е-9 визээр БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр аж үйлдвэрийн салбарт ажиллахаар

ирж буй 24, үйлчилгээний салбарт ажиллахаар 8 иргэнд Нийгмийн даатгалын тухай ойлголт, өөрийн орны тэтгэврийн даатгалд хамрагдаж, ирээдүйн нийгмийн баталгаагаа хангах, тэтгэврийн даатгалын шимтгэлийг БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд давхар төлөхгүй, тус улсын хуулийн дагуу заавал хамрагдах тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх боломж, Сайн дурын даатгалын гэрээг хэрхэн байгуулах тухай сургалт зохион байгуулж зөвлөгөө мэдээлэл өгсөн.

- 2026 оны 07 дугаар сарын 05-ны өдөр “Монголын нэг өдөр Тэжон Монгол наадам-2026” наадамд 62 хүнд, 2026 оны 07 дугаар сарын 06-ны өдөр Чонан наадамд 140 хүнд, 2026 оны 07 дугаар сарын 12-ны өдөр Чэжү хотын наадамд 120 хүн, нийт 322 хүнд явуулын үйлчилгээ үзүүлсэн. Дээрх өдрүүдэд БНСУ-д суугаа МУ-ын Элчин сайдын яамны Консулын газартай хамтран оролцсон.
- БНСУ-д оршин сууж байгаа Монгол Улсын иргэдийн амьдарч оршин суух нөхцөл, ажил эрхлэлт, нас хүйс болон нийгмийн даатгалд даатгуулсан байдал, нийгмийн даатгалын талаарх ойлголт хэр зэрэг байгааг танин мэдэх зорилгоор 23 иргэнээс судалгаа авсан.

- - - оОо - - -